



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-5

1.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	4-5
---	-----

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын 11 дүгээр
сарын 11-ний өдөр /Мягмар гараг/-ийн хамтарсан
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 54 гишүүнээс 28 гишүүн хүрэлцэн ирж, 51.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 56 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баясгалан, А.Ундраа, С.Цэнгүүн;

Чөлөөтэй: Ч.Анар, Ц.Баатархүү, Х.Булгантуяа, Р.Сэддорж, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Ж.Бат-Эрдэнэ, Х.Болормаа, Б.Жавхлан, Б.Жаргалан, П.Мөнхтулга, З.Мэндсайхан, П.Сайнзориг, Б.Тулга, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 минут үргэлжилж, 54 гишүүнээс 34 гишүүн хүрэлцэн ирж, 62.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их засаг” танхим 16 цаг 56 минут

ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Ганхуяг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 51.9 хувьтай бүрдсэн тул 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хамтарсан хуралдаан нээснийг мэдэгдье.

Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, 3 дахь хэлэлцүүлэг. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье ээ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Ням-Осорын Учрал Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Баярсайханы Баярдаваа Монголбанкны Мөнгөний бодлогын газрын дарга, Сэрээнэндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагваагийн Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын Ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Монгол Улсын Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.3-т 3 дахь хэлэлцүүлгээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороод төслийн эцсийн хувилбарыг бэлтгэн танилцуулгын хамт нэгдсэн хуралдаанд оруулна аа гэж заасны дагуу төслийн эцсийн хувилбарыг бэлтгэн та бүхэнд тараасан болно оо.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 онд Төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбартай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 онд төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна аа.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаан дууслаа. Байнгын хорооны гишүүд болон ажлын хэсэгт баярлалаа.

16.59 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА